



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 13 (442)

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- *Ерөнхий шүүгчээр томилох тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- *Зарим яамдын үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр зөвшөөрөх, зохион байгуулалтын бүтэц батлах тухай*

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

- *Эрүүгийн хуулийн 181 дүгээр зүйлийн 181.3 дахь хэсгийн зарим заалтыг тайлбарлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2006 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2006 оны дөрөвдүгээр сарын 7

№13 (442)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

205.	Ерөнхий шүүгчээр томилох тухай	Дугаар 83	345
------	--------------------------------	-----------	-----

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

206.	Зарим яамдын үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр зөвшөөрөх, зохион байгуулалтын бүтэц батлах тухай	Дугаар 27	346
207.	Ажилд томилох тухай	Дугаар 29	359
208.	Ажилд түр томилох тухай	Дугаар 31	359
209.	Төрийн өмчийн хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай	Дугаар 32	360
210.	Тооны дээд хязгаар тогтоох тухай	Дугаар 33	360
211.	Мөнгөн төлбөрийн хэмжээг тогтоох тухай	Дугаар 34	361

Гурав. МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

212.	Автотээврийн тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг тайлбарлах тухай	Дугаар 05	361
213.	Эмийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн зарим заалтыг тайлбарлах тухай	Дугаар 06	362
214.	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг тайлбарлах тухай	Дугаар 07	363
215.	Шүүхийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсгийн зарим заалтыг тайлбарлах тухай	Дугаар 08	364

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 03 дугаар сарын 31-ний өдөр

Дугаар 83

Улаанбаатар хот

Ерөнхий шүүгчээр томилох тухай

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль"-ийн 12 дугаар зүйлийн 16, "Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх заалтыг тус тус баримтлан Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Цэвэгмидийн Зоригийг Нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгчээр томилсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 3 дугаар сарын 1-ний одор

Дугаар 27

Улаанбаатар хот

Зарим яамдын үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр зөвшөөрөх, зохион байгуулалтын бүтэц батлах тухай

Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 10.1-ийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Барилга, хот байгуулалтын яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг 1 дүгээр хавсралт ёсоор, Зам, тээвэр, аялал жуулчлалын яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг 2 дугаар хавсралт ёсоор тус тус зөвшөөрсүгэй.

2. Дараахь яамдын зохион байгуулалтын бүтцийг дор дурдсанаар баталсугай:

а/Барилга, хот байгуулалтын яам:

1/Хот байгуулалтын бодлого зохицуулалтын газар;

2/Газрын харилцаа, эрхийн бүртгэлийн бодлого зохицуулалтын газар;

3/Барилга, орон сууц, нийтийн аж ахуйн бодлого зохицуулалтын газар;

4/Санхүү, хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны газар;

5/Төрийн захиргааны удирдлагын газар /Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэстэй/;

б/Батлан хамгаалах яам:

1/Стратегийн удирдлага, төлөвлөлтийн газар /Улсын дайчилгааны хэлтэстэй/;

2/Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар;

3/Төрийн захиргааны удирдлагын газар;

4/Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний газар;

5/Гадаад хамтын ажиллагааны хэлтэс;

6/Санхүүгийн хэлтэс.

в/Зам, тээвэр, аялал жуулчлалын яам:

1/Авто замын газар;

2/Тээврийн газар /Авто тээвэр, усан замын тээврийн хэлтэстэй/;

3/Аялал жуулчлалын газар;

4/Шуудангийн газар;

5/Санхүү, хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны газар /Гадаад хамтын ажиллагааны хэлтэстэй/;

6/Төрийн захиргааны удирдлагын газар /Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэстэй/.

3. Дээрх яамдын орон тооны хязгаарыг дор дурдсанаар тогтоосугай:

Яам	Орон тооны хязгаар
Барилга, хот байгуулалтын яам	70
Батлан хамгаалах яам	58
Зам, тээвэр, аялал жуулчлалын яам	70

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Барилга, хот байгуулалтын яамны зохион байгуулалтын бүтэц, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр батлах тухай" Засгийн газрын 2004 оны 10 дугаар сарын 8-ны өдрийн 201 дүгээр тогтоолын 4 дүгээр зүйлээс бусад зүйл, заалт, "Зам, тээвэр, аялал жуулчлалын яамны зохион байгуулалтын бүтэц, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр батлах тухай" Засгийн газрын 2004 оны 10 дугаар сарын 8-ны өдрийн 202 дугаар тогтоолын 4 дүгээр зүйлээс бусад зүйл, заалт, "Зарим яамдын зохион байгуулалтын бүтэц, үйл ажиллагааны стратеги,

бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр зөвшөөрөх, бүтэц батлах тухай" Засгийн газрын 2004 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн 236 дугаар тогтоолын 2 дугаар зүйлийн "в" заалт, 3 дугаар зүйлийн "Батлан хамгаалах яам" гэснийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА С.БАТБОЛД

Засгийн газрын 2006 оны 27 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ХӨТӨЛБӨР

1. Нийтлэг үндэслэл

1.1. Оршил

Барилга, хот байгуулалтын яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр (цаашид "Хөтөлбөр" гэх)-т Барилга, хот байгуулалтын сайдын болон Засгийн газрын танхимын шийдвэрийг боловсруулан гаргах, хэрэгжүүлэх, дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамж, төрийн захиргааны удирдлага, хэрэгжилтийг зохицуулалтаар хангах, эдийн засаг, хяналт шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх асуудлыг хамарсан Барилга, хот байгуулалтын яамны стратеги болон бүтцийн загварыг тодорхойлов.

1.2. Үндэслэл

Хөтөлбөрийг УИХ-ын 1996 оны 38 дугаар тогтоолоор зөвшөөрсөн "Монгол Улсын Төрөөс Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлийн талаар баримтлах бодлого"-ын баримт бичгийг үндэслэв.

1.3. Хууль тогтоомжийн орчин

Хөтөлбөрийг дор дурдсан хуулийн хүрээнд хэрэгжүүлнэ:

- Монгол Улсын Үндсэн хууль
- Монгол Улсын Засгийн газрын тухай хууль
- Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хууль
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Монгол Улсын Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль
- Монгол Улсын Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль
- Монгол Улсын Төрийн албаны тухай хууль
- Монгол Улсын Бусчилсан хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хууль
- Монгол Улсын Барилгын тухай хууль
- Монгол Улсын Хот байгуулалтын тухай хууль
- Монгол Улсын Газрын тухай хууль
- Монгол Улсын Орон сууцны тухай хууль
- Монгол Улсын Орон сууц хувьчлах тухай хууль
- Монгол Улсын Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хууль

- Монгол Улсын Хот, суурин газрын усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль
- Монгол Улсын Геодези, зураг зүйн тухай хууль
- Монгол Улсын Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хууль
- Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгох журмын тухай хууль
- Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Бусад хууль тогтоомж

1.4. Арга зүй

Хөтөлбөрийг боловсруулахдаа олон улсын туршлага, салбарын удирдлага, санхүүжилтийн шинэчлэлт өөрчлөлт, үйл ажиллагаа /business-ны төлөвлөлт болон дахин инженерчлэл, байгууллагын өөрчлөлтийн арга зүйг хэрэглэв.

1.5. Чиглэлийн яамны үүрэг хариуцлагын хуваарь

Барилга, хот байгуулалтын яам Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд үүрэг хүлээж Барилга, хот байгуулалтын сайд, Засгийн газрын танхимд бүх талын зөвлөгөө дэмжлэг үзүүлнэ.

Барилга, хот байгуулалтын яам салбарын бодлогын удирдамжаар хангах, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан салбарын зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, уялдуулан зохицуулах, бодлого шийдвэрийн хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх, салбарын харилцан уялдаа холбоог хангах асуудалд өргөн хүрээтэй хандаж, зөв зохистой удирдахад анхаарлаа төвлөрүүлнэ.

Барилга, хот байгуулалтын яам нь Засгийн газрын барилга, хот байгуулалтын зөвлөхийн үүрэг хүлээнэ.

1.6. Стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр

Барилга, хот байгуулалтын яамны стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр нь дор дурдсан хүрээний үйлчлүүлэгч, хэрэглэгчийг хамаарна:



Барилга, хот байгуулалтын яамны үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгч нь Барилга, хот байгуулалтын сайд, Засгийн газрын танхим байна.

Стратегийн удирдлага, зохицуулалт нь дээр дурдсан үйлчлүүлэгч, хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээг хангахтай холбогдон үүсэх олон төрлийн нарийн түвэгтэй харьцааг эрх зүйн орчны хүрээнд зохицуулахад чиглэгдэнэ.

Төсвийн ерөнхийлөн захирагч (Барилга, хот байгуулалтын сайд)-тай төсвийн ерөнхий менежер (Төрийн нарийн бичгийн дарга) бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээ байгуулан дүгнэж ажиллана.

Барилга, хот байгуулалтын яамны стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээг хангах үйлчилгээний хүрээ, төрөл, хэлбэрийг хэрэгцээний эх үүсвэр бүрээр тогтоож яамны зохион байгуулалтын бүтцийн зорилт, чиг үүргийг үйл ажиллагаа /бизнес/-ны хэтийн төлөвлөгөөтэй уялдуулан нарийвчлан тогтоож, газар, хэлтсийн болон төрийн албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтод тусгаж хэрэгжүүлнэ.

2. Барилга, хот байгуулалтын яамны үйл ажиллагааны стратеги

2.1. Үйл ажиллагааны стратегийн мөн чанар
Барилга, хот байгуулалтын яамны үйл ажиллагааны мөн чанар нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Барилга, хот

байгуулалтын сайдын эрхлэх ажлын хүрээний асуудлыг хэрэгжүүлэхэд чиглэсэн Барилга, хот байгуулалтын сайдын үйл ажиллагаанд өндөр мэргэшлийн, цаг үеэ олсон, шуурхай зөвлөгөө, бүх талын дэмжлэг үзүүлэхэд оршино.

2.2. Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл

Барилга, хот байгуулалтын яам нь үйл ажиллагааны дор дурдсан тэргүүлэх чиглэлтэй ажиллана:

2.2.1. Хот байгуулалтын хамгийн үр ашигтай тогтолцоог бий болгон хөгжүүлэх;

2.2.2. Газрын харилцаа, геодези зураглалыг зохиистой бодлогоор удирдах, иргэн бүрт газрыг хувьчлах, газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах бодлого боловсруулж хэрэгжүүлэх;

2.2.3. Барилга, нийтийн аж ахуйн үйлчилгээг хэтийн болон ойрын зорилгоор хөгжүүлж хүн амыг тохилго орон сууцаар хангах бодлого боловсруулж хэрэгжүүлэх;

2.2.4. Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн бүртгэлийн нэгдсэн сүлжээг бий болгон хөгжүүлэх;

2.2.5. Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын бодлого чиглэлийг гаргаж салбарын хэмжээнд хэрэгжүүлэх.

Барилга, хот байгуулалт, газрын харилцаа, орон сууц, нийтийн аж ахуйн бодлогын үр нөлөөг дээшлүүлэх замаар хүн амын ая тухтай, аюулгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлэх.

2.3. Үйл ажиллагааны эрхэм зорилго:

бүртгэлийн нэгдсэн сүлжээг бий болгон хөгжүүлэх бодлогын удирдамжаар хангах.

2.4. Үйл ажиллагааны стратегийн гол зорилт

2.5.3. Үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд:

Барилга, хот байгуулалтын яам нь эрхэм зорилгыноо хүрээнд үйл ажиллагааны стратегийн дор дурдсан зорилтыг хэрэгжүүлнэ:

2.5.3.1. Барилгажилт, барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлогын удирдамжаар хангах;

2.4.1. Хот төлөвлөлт, хот байгуулалт, нутагшил суурьшлын бодлогын удирдамжаар хангах;

2.5.3.2. Иргэдийг орон сууцаар хангах бодлогыг боловсронгуй болгон хөгжүүлэх;

2.4.2. Газар, геодези, зураг зүй болон эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлтэй холбогдсон бодлогын удирдамжаар хангах;

2.5.3.3. Нийтийн аж ахуйн үйлчилгээг хөгжүүлэх бодлогын удирдамжаар хангах.

2.4.3. Барилга, орон сууц, нийтийн аж ахуйн бодлогын удирдамжаар хангах;

2.5.4. Үйл ажиллагааны стратегийн 4 дүгээр зорилтын хүрээнд:

2.4.4. Салбарын эдийн засаг, гадаад хамтын ажиллагааг бодлого зохицуулалтаар хангах;

2.5.4.1. Салбарын эдийн засаг, хөрөнгө оруулалтын төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах;

2.4.5. Төрийн захиргааны удирдлагыг хангах, бодлогын хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх.

2.5.4.2. Гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх, зохицуулах;

2.5. Үйл ажиллагааны гол зорилт

2.5.4.3. Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөв зохиох, зарцуулалтад хяналт тавих, тайлагнах үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

Барилга, хот байгуулалтын яамны стратегийн зорилт тус бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны дор дурдсан зорилтыг дөвшүүлж ажиллана:

2.5.5. Үйл ажиллагааны стратегийн 5 дугаар зорилтын хүрээнд:

2.5.1. Үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд:

2.5.5.1. Төрийн захиргааны удирдлагаар хангах;

2.5.1.1. Нутагшилт, суурьшлын бодлогын удирдамжаар хангах, зохицуулах;

2.5.5.2. Хүний нөөцийн удирдлагаар хангах;

2.5.1.2. Хот, тосгоны тогтолцоог боловсронгуй болгох бодлогын удирдамжаар хангах, зохицуулах;

2.5.5.3. Салбартаа мэдээллийн технологийг хөгжүүлэх, барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн чиглэлээрх бодлогын хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх.

2.5.1.3. Хот төлөвлөлт, хот байгуулалтын бодлогын удирдамжаар хангах.

2.6. Үйл ажиллагааны зорилт

2.5.2. Үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд:

Барилга, хот байгуулалтын яамны үйл ажиллагааны гол зорилт тус бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны зорилтыг тус яам тодорхойлж хэрэгжүүлнэ.

2.5.2.1. Газрын харилцааны бодлогын удирдамжаар хангах;


2.7. Үйл ажиллагааны стратеги, бүтэц, зохион байгуулалтын уялдаа /загвар/

2.5.2.2. Геодези, зураг зүйн бодлогын удирдамжаар хангах;

Барилга, хот байгуулалтын яамны үйл ажиллагаа (бизнес)-ны стратеги, бүтэц, зохион байгуулалтын уялдаа /загвар/-г дор дурдсанаар тодорхойлж байна:

2.5.2.3. Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбогдсон эд хөрөнгийн бусад эрхийн улсын

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА (БИЗНЕС)-НЫ СТРАТЕГИ, БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН УЯЛДАА /загвар/



3. Барилга, хот байгуулалтын яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, санал болгож буй зохион байгуулалтын бүтэц, тэдгээрийн чиг үүрэг:

3.1. Бүтцийн ерөнхий тогтолцоо боловсруулахад баримталсан зарчим

1. Яамны стратегийн зорилтыг бүтцэд тусгасан байх зарчим (Барилга, хот байгуулалтын яамны үйл ажиллагаа, бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтэц нь түүний үйл ажиллагааны стратеги зорилттой уялдсан байх);

2. Эрх мэдлийн ялгаа зааг нь тодорхой, итгэл хүлээхүйц байх зарчим (бүтцийн нэгжүүд, тэдгээрийн удирдах албан тушаалын түвшин, нэр нь аль нэгж ямар асуудал эрхэлдэг, аль албан тушаал ямар эрх мэдэлтэй болохыг тодорхой мэдэж болохуйц байх, тэдгээрийн ажлын уялдаа, ажиллах чадвар нь итгэл хүлээхүйц байх);

3. Үзэгдэхүйц үйлчилгээний болон стратегийн удирдлагын баримжаатай байх зарчим (байгууллагын нэр, бүтцээс тухайн байгууллагын үйл ажиллагааны дүр төрх харагдахуйц байх, тухайлбал яамны бүтэц, бүтцийн нэгжийн нэр нь түүний үйл ажиллагааны стратегийг тусгасан байх);

4. Бүтцийн нэгж энгийн байх зарчим (Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргаас хамгийн доод нэгжээ хүртэл гуравас дээшгүй шат дамжлагатай байх);

5. Тэнцвэрийг хангах, хяналтын хүрээг тогтоох зарчим (байгууллагын үйл ажиллагааны стратеги, бүтэц хоёрын зөв зохиистой тэнцвэрийг хангах замаар аль болох хялбар удирдах, хянах боломжтой байх, үйл ажиллагааны стратегийн зорилтыг аль болохоор оновчтой бүлэглэх замаар бүтцийн ерөнхий тогтолцоог тогтоосон байх. Энэ нь удирдлагын чиг үүрэг, хүн хүчний болон бусад нөөцийг зөв хуваарилан хэрэглэгчийнхээ хэрэгцээнд нийцсэн үйлчилгээг үзүүлэх боломжийг бүрдүүлсэн байх);

6. Улс төрийн хувьд төвийг сахисан байх зарчим (Барилга, хот байгуулалтын яамны төрийн захиргааны албан хаагч нь сайд, Засгийн газар (танхим), бусад үйлчлүүлэгч буюу хэрэглэгчдэд улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүй төвийг сахисан өндөр мэргэжлийн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх);

7. Хангалттай чадавхи, бодитой үйл ажиллагааны зарчим (үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар, зохион байгуулалтын бүтэц нь чадавхиа бүрэн илрүүлэхэд чиглэсэн хэрэгжихүйц бөгөөд ажиллах чадвартай байх).

3.2. Үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар

Дээрх зарчим болон Барилга, хот байгуулалтын яамны үйл ажиллагаа (бизнес)-ны загварыг үндэслэн тус яамны үйл ажиллагааны бүтцийн дор дурдсан ерөнхий тогтолцооны загварыг санал болгож байна:

Барилга, хот байгуулалтын яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар



3.3. Зохион байгуулалтын бүтэц

Барилга, хот байгуулалтын яамны үйл ажиллагаа /бизнес/-ны стратегийн болон үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны

загварыг үндэслэн тус яам зохион байгуулалтын бүтцийн дор дурдсан нэгжтэй байна:

1. Хот байгуулалтын бодлого зохицуулалтын нэгж, түүний үндсэн чиг үүрэг. Энэ

нэгжийн үндсэн чиг үүрэг нь хот байгуулалтын талаархи бодлого боловсруулах, бодлогын шинжилгээ хийх, бодлогын хувилбар гаргах, хүн амын нутагшил, суурьшлын хөгжил, бүс нутгийн хөгжил, хот, тосгоны ерөнхий төлөвлөгөөний харилцан уялдааг зохицуулах, хот байгуулалтын дүрэм, журам, норм боловсруулах чиглэлийг тодорхойлох, батлуулах, энэ талаархи үйл ажиллагааг зохицуулах явдал мөн.

Энэ нэгж нь Барилга, хот байгуулалтын сайд, дэд сайд, Засгийн газрыг стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах, бодлогын зохицуулалттай холбогдсон шийдвэр гаргах механизмд дэмжлэг үзүүлэх, Засгийн газрын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайдыг шаардлагатай мэдээлэл, өндөр мэргэшлийн цаг үеэ олсон шуурхай зөвлөгөө, үйлчилгээ, бүх талын дэмжлэгээр хангана. Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Барилга, хот байгуулалтын сайд, Засгийн газар байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь бусад яам болон хэвлэл, мэдээлэл, олон нийтийн байгууллага байна.

II. Барилга, орон сууц, нийтийн аж ахуйн бодлого зохицуулалтын нэгж, түүний үндсэн чиг үүрэг. Энэ нэгжийн үндсэн чиг үүрэг нь барилга, орон сууц, нийтийн аж ахуйн талаархи бодлого боловсруулах, бодлогын шинжилгээ хийх, бодлогын хувилбар гаргах, барилга, орон сууц, нийтийн аж ахуйн салбарын хэтийн болон дунд хугацааны стратегийн төлөвлөгөө, хөгжлийн бодлого, хөтөлбөр, төсөл боловсруулах, шинэ техник, технологийг нэвтрүүлэх чиглэлийг тогтоох, барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах болон барилга угсралтын ажил, үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай эвшөөрөл олгох, барилга, орон сууц, нийтийн аж ахуйн ашиглалтын норм, норматив, барилгын норм, дүрмийг боловсруулах чиглэлийг тодорхойлох, хариуцсан асуудлын хүрээнд боловсруулсан дүрэм, норм, норматив, холбогдох баримт бичгийг хянаж батлуулах зэрэг болно.

Энэ нэгж нь Барилга, хот байгуулалтын сайд, дэд сайд, Засгийн газрыг стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах, бодлогын зохицуулалттай холбогдсон шийдвэр гаргах механизмд дэмжлэг үзүүлэх, Засгийн газрын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайдыг шаардлагатай мэдээлэл, өндөр мэргэшлийн цаг үеэ олсон шуурхай зөвлөгөө, үйлчилгээ, бүх талын дэмжлэгээр хангана. Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Барилга, хот байгуулалтын сайд, Засгийн газар байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь бусад яам болон хэвлэл, мэдээлэл, орон сууцны олон нийтийн байгууллага байна.

III. Газрын харилцаа, эрхийн бүртгэлийн бодлого зохицуулалтын нэгж, түүний үндсэн чиг үүрэг. Энэ нэгжийн үндсэн чиг үүрэг нь газрын харилцаа, газар өмчлөх, эрхийн бүртгэлийн талаархи бодлого боловсруулах, бодлогын

шинжилгээ хийх, бодлогын хувилбар гаргах, хөтөлбөр, төсөл боловсруулах, газрын нэгдсэн сан, газрын кадастр, геодези, зураг зүйн талаар эрх зүйн хүрээнд холбогдох дүрэм, журам боловсруулах, газар зохион байгуулалт, газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагад тусгай эвшөөрөл олгох, олон улсын гэрээгээр геодези, зураг зүйн асуудлаар Монгол Улсын хүлээсэн үүргийн биелэлтийг хангуулах, эд хөрөнгө өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн улсын бүртгэлийн нэгдсэн сүлжээг бий болгон хөгжүүлэх зэрэг болно.

Энэ нэгж нь Барилга, хот байгуулалтын сайд, дэд сайд, Засгийн газрыг стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах, бодлогын зохицуулалттай холбогдсон шийдвэр гаргах механизмд дэмжлэг үзүүлэх, Засгийн газрын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайдыг шаардлагатай мэдээлэл, өндөр мэргэшлийн цаг үеэ олсон шуурхай зөвлөгөө, үйлчилгээ, бүх талын дэмжлэгээр хангана. Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Барилга, хот байгуулалтын сайд, Засгийн газар байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, газрын албад, хэвлэл, мэдээлэл, олон нийтийн байгууллага, иргэд байна.

IV. Санхүү, хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны нэгж, түүний үндсэн чиг үүрэг. Энэ нэгжийн үндсэн чиг үүрэг нь төсвийн удирдлага, санхүүжилттэй холбоотой хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, салбарын хэтийн болон дунд хугацааны стратегийн төлөвлөгөө, үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх санхүү, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг төлөвлөх, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөв зохиох, зарцуулалтад хяналт тавих, тайлагнах, улсын төсвийн хөрөнгө оруулалтын салбарын төлөвлөлт, зохицуулалтаар хангах, салбарын хэмжээнд хэрэгжүүлэх гадаадын зээл, тусламж, эдийн засгийн хамтын ажиллагааны стратеги, хөтөлбөрийг холбогдох газруудтай хамтран боловсруулах, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх, сайдын эрхлэх ажлын хүрээний сангуудын бүрдүүлэлт, зарцуулалт, тайлагналтад хяналт тавих зэрэг болно.

Энэ нэгж нь Барилга, хот байгуулалтын сайд, дэд сайд, Засгийн газрыг стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах, бодлогын зохицуулалттай холбогдсон шийдвэр гаргах механизмд дэмжлэг үзүүлэх, Засгийн газрын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайдыг шаардлагатай мэдээлэл, өндөр мэргэшлийн цаг үеэ олсон шуурхай зөвлөгөө, үйлчилгээ, бүх талын дэмжлэгээр хангана. Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний хэрэглэгч нь Сангийн яам, Гадаад хэргийн яам, аймаг, нийслэлийн Засаг дарга, захиалагч болон бусад байгууллага, аж ахуйн нэгж байна.

Ү. Төрийн захиргааны удирдлагын нэгж, түүний үндсэн чиг үүрэг. Энэ нэгж нь яамны аппаратын дотоод ажлыг удирдлага, зохицуулалтаар хангах, хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, сайдын болон яамны удирдлагын шийдвэр, эрх бүхий байгууллагаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтэд хяналт тавих, сайдын эрхлэх ажлын хүрээнд байгууллагуудтай харилцаа холбоо тогтоох, хамтран ажиллах асуудлыг зохион байгуулж хэрэгжүүлэх, яамны үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөг боловсруулан мөрдүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, сайд болон яамны удирдлагад шаардлагатай мэдээлэл, хууль эрх зүйн зөвлөгөө өгөх, албан хэрэг хөтөлбөр, архив, нууцын асуудлыг хариуцаж яаманд гаргасан санал, гомдол, өргөдлийг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, салбарын мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх, түүнийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, салбарын мэдээллийн технологийн бодлогыг хэрэгжүүлэх, хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, хууль тогтоомж, бодлого, гэрээ, хэлэлцээр, хөтөлбөр, төсөл, төлөвлөгөөний

хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх зэрэг болно.

Энэ нэгж нь Барилга, хот байгуулалтын сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн даргад болон яамны аппаратад шийдвэр боловсруулан гаргах, хэрэгжүүлэхэд эрх зүйн болон дотоод үйлчилгээг үзүүлэх, шаардлагатай мэдээлэл, зөвлөгөө, дэмжлэгээр хангах, удирдлагын соёл, цадавхийг дээшлүүлэх, тэргүүний арга барил, туршлагыг нэвтрүүлэх, Төрийн захиргааны албан хаагчдыг сургаж хөгжүүлэх, тэдний үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах замаар хэрэгжүүлнэ. Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Барилга, хот байгуулалтын сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, яамны нэгжүүд, төрийн захиргааны албан хаагчид байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь төсөвт байгууллага, аж ахуйн нэгж, бусад хэрэглэгч байна. Энэ нэгжийн үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Хууль зүй, дотоод хэргийн яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, бусад байгууллага байна.

Засгийн газрын 2006 оны 27 дугаар тогтоолын 2 дугаар хэсэрлэлт

ЗАМ, ТЭЭВЭР, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН ХӨТӨЛБӨР

1. Нийтлэг үндэслэл

1.1. Оршил

Зам, тээвэр, аялал жуулчлалын яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн хөтөлбөр (цэашид "Хөтөлбөр" гэх)-т Зам, тээвэр, аялал жуулчлалын сайдын болон Засгийн газрын танхимын шийдвэрийг боловсруулан гаргах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн стратегийн төлөвлөлт, бодлого боловсруулах, бодлогын хэрэгжилтийг зохицуулах удирдамж, төрийн захиргааны удирдлага, зохицуулалтаар хангах, бодлогын хэрэгжилтэд хяналт шинжилгээ (мониторинг) хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, сайдын төсвийн багцын төлөвлөлт, санхүүжилт, гадаад хамтын ажиллагааны асуудлыг хамарсан Зам, тээвэр, аялал жуулчлалын яамны үйл ажиллагааны стратегийн болон бүтцийн загварыг тодорхойлох.

1.2. Үндэслэл

Хөтөлбөрийг Улсын Их Хурлын 1996 оны 38 дугаар тогтоолоор зөвшөөрсөн "Монгол Улсын төрөөс Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлийн талаар баримтлах бодлого"-ын баримт бичгийг үндэслэн боловсруулав

1.3. Хууль тогтоомжийн орчин

Хөтөлбөрийг дор дурдсан хуулийн хүрээнд хэрэгжүүлнэ:

- Монгол Улсын Үндсэн хууль
- Засгийн газрын тухай хууль

- Яамны эрх зүйн байдлын тухай хууль
- Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль

- Төрийн албаны тухай хууль
- Иргэний нисэхийн тухай хууль
- Харилцаа холбооны тухай хууль
- Төмөр замын тээврийн аюулгүй байдлын тухай хууль
- Авто тээврийн тухай хууль
- Далай ашиглах тухай хууль
- Шуудангийн тухай хууль
- Аялал жуулчлалын тухай хууль
- Усан замын тээврийн тухай хууль
- Авто замын тухай хууль
- Замтад хууль тогтоомж

1.4. Арга зүй

Хөтөлбөрийг боловсруулахад олон улсын туршлага, өөрчлөлтийн удирдлага, үйл ажиллагаа (бизнес)-ны төлөвлөлт, дахин инженерчлэл, байгууллагын өөрчлөлтийн болон урьд хуримтлагдсан арга зүй, мэдээллийг ашиглав.

1.5. Чиглэлийн яамны үүрэг хариуцлагын хуваарь

Зам, тээвэр, аялал жуулчлалын яам нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тус яамны чиглэлээр тусгагдсан зорилгыг хэрэгжүүлэх үүрэг хүлээж, Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд, Засгийн газрын танхимд бүх талын зөвлөгөө,

дэмжлэг үзүүлнэ. Зам, тээвэр, аялал жуулчлалын яам нь салбарын бодлого, төлөвлөлт болон төсвийн зарцуулалтын тэнцвэр, харилцан уялдаа холбоог хангах асуудалд Засгийн газар, яамны өндөрлөгөөс өргөн хүрээтэй хандаж, зөв зохиогчийг удирдахад анхаарлаа төвлөрүүлнэ. Засгийн газрын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэг бүхий чиглэлийн яамдын нэг болох Зам, тээвэр, аялал жуулчлалын яам нь

эрхэлсэн асуудлын чиглэлээр Засгийн газрын зөвлөхийн үүрэг хүлээнэ.

1.6. Стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр

Зам, тээвэр, аялал жуулчлалын яамны стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэрт дор дурдсан үйлчлүүлэгч буюу хэрэглэгч хамрагдана:

ЗАМ, ТЭЭВЭР, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ СТРАТЕГИЙН УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭРЭГЦЭЭНИЙ ЭХ ҮҮСВЭР



Зам, тээвэр, аялал жуулчлалын яамны үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгч нь Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд, Засгийн газар байна. Стратегийн удирдлага, зохицуулалт нь дээр дурдсан хэрэгцээний эх үүсвэр, үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийн эрэлт хэрэгцээг хангахтай холбогдон үүсэх олон төрлийн нарийн түвэгтэй харилцааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохицуулахад чиглэнэ. Зам, тээвэр, аялал жуулчлалын яамны стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээг хангах үйлчилгээний хүрээ, төрөл, хэлбэрийг хэрэгцээний эх үүсвэр тус бүрээр тогтоон, тус яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн зорилт, чиг үүрэг, төрийн албан хаагчдын ажлын байр (албан тушаал)-ны тодорхойлолтод нарийвчлан тусгаж хэрэгжүүлнэ.

2. Зам, тээвэр, аялал жуулчлалын яамны үйл ажиллагааны стратеги

2.1. Үйл ажиллагааны стратегийн мөн чанар

Зам, тээвэр, аялал жуулчлалын яамны үйл ажиллагааны стратегийн мөн чанар нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Зам, тээвэр,

аялал жуулчлалын сайдын эрхлэх ажлын хүрээний зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн Зам, тээвэр, аялал жуулчлалын сайдын үйл ажиллагаанд өндөр мэргэшлийн, цаг үеэ олсон, шуурхай зөвлөгөө, бүх талын дэмжлэг үзүүлэхэд оршино.

2.2. Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл:

Зам, тээвэр, аялал жуулчлалын яам нь үйл ажиллагааны дор дурдсан тэргүүлэх чиглэлтэй ажиллана:

2.2.1. Зам, тээврийн оновчтой сүлжээ, аялал жуулчлал, шуудангийн үйлчилгээг өргөтгөх, эдийн засгийн өсөлтийг хангахуйц зам, тээвэр, аялал жуулчлал, шуудангийн сүлжээний үндсийг бий болгох;

2.2.2. Салбарын удирдлагын болон бүтцийн өөрчлөлтийг боловсронгуй болгох;

2.2.3. Тухайн салбарт хувийн хэвшлийг дэмжиж, өмчийн олон хэлбэрийн өрсөлдөх орчинг бий болгох;

2.2.4. Бүх төрлийн тээврийн хөгжлийг хангаж, ажлын уялдааг сайжруулах;



2.2.5. Салбарын санхүү, эдийн засгийн төлөвлөлт, хөрөнгө оруулалтын үр дүнг дээшлүүлэх;

2.2.6. Салбарын хамтын ажиллагааг өргөжүүлж, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих.

2.3. Үйл ажиллагааны эрхэм зорилго

Зам, тээвэр, аялал жуулчлалын яамны үйл ажиллагааны эрхэм зорилго нь эдийн засгийн өсөлтийг хангахуйц зам, тээврийн сүлжээ, аялал жуулчлал, шуудангийн үйлчилгээг өргөжүүлэн хөгжүүлэх явдал мөн.

2.4. Үйл ажиллагааны стратегийн зорилт

Зам, тээвэр, аялал жуулчлалын яам нь эрхэм зорилгынхоо хүрээнд үйл ажиллагааны дор дурдсан стратегийн зорилтыг хэрэгжүүлнэ:

2.4.1. Авто зам, тээвэр, аялал жуулчлал, шуудангийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах, бодлогын хэрэгжилтийг зохицуулах;

2.4.2. Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах;

2.4.3. Салбарын бодлогын хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх;

2.4.4. Салбарын санхүү, хөрөнгө оруулалт, төлөвлөлт, түүний үр ашгийг өсгөх, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжин хөгжүүлэх.

2.5. Үйл ажиллагааны гол зорилт

Зам, тээвэр, аялал жуулчлалын яамны стратегийн зорилт тус бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны дор дурдсан гол зорилтыг дэвшүүлэн ажиллана:

2.5.1. Үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд:

2.5.1.1. Авто замын салбарын урт, дунд, богино хугацааны стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах;

2.5.1.2. Авто замын салбарын бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл боловсруулах;

2.5.1.3. Авто замын бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг зохицуулах;

2.5.1.4. Тээврийн салбарын урт, дунд, богино хугацааны стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах;

2.5.1.5. Тээврийн салбарын бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл боловсруулах;

2.5.1.6. Тээврийн бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг зохицуулах;

2.5.1.7. Аялал жуулчлалын салбарын урт, дунд, богино хугацааны стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах.

2.5.1.8. Аялал жуулчлалын салбарын бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл боловсруулах;

2.5.1.9. Аялал жуулчлалын бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг зохицуулах;

2.5.1.10. Шуудангийн салбарын урт, дунд, богино хугацааны стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах;

2.5.1.11. Шуудангийн салбарын бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл боловсруулах;

2.5.1.12. Шуудангийн бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг зохицуулах.

2.5.2. Үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд:

2.5.2.1. Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах;

2.5.2.2. Хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах.

2.5.3. Үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд:

2.5.3.1. Авто зам, тээвэр, аялал жуулчлал, шуудангийн салбарын бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, төслийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх;

2.5.3.2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт Зам, тээвэр, аялал жуулчлалын сайдын эрхлэх ажлын хүрээнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх.

2.5.4. Үйл ажиллагааны стратегийн 4 дүгээр зорилтын хүрээнд:

2.5.4.1. Салбарын санхүү, эдийн засгийн төлөвлөлт, Зам, тээвэр, аялал жуулчлалын сайдын төсвийн багцын төлөвлөлт, зохицуулалт, тайлагнах үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

2.5.4.2. Гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх, гадаадын зээл, тусламж, хөрөнгө оруулалтыг дэмжин хөгжүүлэх.

2.6. Үйл ажиллагааны зорилт

Зам, тээвэр, аялал жуулчлалын яамны үйл ажиллагааны гол зорилт тус бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны зорилтыг тус яам тодорхойлж хэрэгжүүлнэ.

2.7. Үйл ажиллагааны стратегийн загвар

Зам, тээвэр, аялал жуулчлалын яамны үйл ажиллагаа (бизнес)-ны стратегийн загварыг дор дурдсанаар тодорхойлж байна:

ЗАМ, ТЭЭВЭР, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА (БИЗНЕС)-НЫ СТРАТЕГИЙН ЗАГВАР

Эрхэм зорилго

Эдийн засгийн өсөлтийг хангахуйц зам, тээвэр, аялал жуулчлал, шуудангийн үйлчилгээг өргөжүүлэн хөгжүүлэх

Үйл ажиллагааны стратегийн зорилт

Авто зам, тээвэр, аялал жуулчлал, шуудангийн салбарын стратегийн бодлого, төлөвлөлт, бодлогын хэрэгжилтийг зохицуулах, удирдамжаар хангах

Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах

Салбарын бодлогын хэрэгжилтэд хяналт шинжилгээ (мониторинг) хийх, үнэлгээ өгөх

Салбарын санхүү, эдийн засаг, хөрөнгө оруулалт, төлөвлөлт, түүний үр шийг нэмэгдүүлэх, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих

Үйл ажиллагааны гол зорилт

-Авто замын салбарын урт, дунд, богино хугацааны стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах
-Авто замын салбарын төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл боловсруулах
-Авто замын бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг нэгтгэн зохион байгуулах

-Тээрийн салбарын урт, дунд, богино хугацааны стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах
-Тээрийн салбарын төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл боловсруулах
-Тээрийн бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг нэгтгэн зохион байгуулах

-Аялал жуулчлалын салбарын урт, дунд, богино хугацааны стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах
-Аялал жуулчлалын салбарын төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл боловсруулах
-Аялал жуулчлалын бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг нэгтгэн зохион байгуулах

-Шуудангийн салбарын урт, дунд, богино хугацааны стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах
-Шуудангийн салбарын төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл боловсруулах
-Шуудангийн бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг нэгтгэн зохион байгуулах

Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах

Хүний нөөцийн удирдлагыг хангах

Салбарын бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төслийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ (мониторинг) хийх, үр дүнд үнэлгээ өгөх

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт эрхлэх ажлын хүрээнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ хийж, хэрэгжилтийг хангуулах.

Салбарын эдийн засгийн бодлого, зам, тээвэр, аялал жуулчлалын сайдын төсвийн төслийн төлөвлөлт, зарцуулалт, тайлагнах үйл ажиллагааг хэрэгжүүлэх

Гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх, эзэл, тусламж, хөрөнгө оруулалтыг дэмжин хөгжүүлэх

3. Зам, тээвэр, аялал жуулчлалын яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, санал болгож буй зохион байгуулалтын бүтэц, тэдгээрийн үүрэг, чиг үүрэг

3.1. Бүтцийн ерөнхий тогтолцоо боловсруулахад баримтлах зарчим

Зам, тээвэр, аялал жуулчлалын яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, санал болгож буй зохион байгуулалтын бүтцийг боловсруулахад дор дурдсан зарчмыг баримтлав:

3.1.1. Яамны стратегийн зорилтыг бүтэцэд тусгасан байх зарчим (тухайн яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтэц нь түүний үйл ажиллагааны стратегийн зорилттой уялдсан байх);

3.1.2. Эрх мэдлийн ялгаа зааг нь тодорхой, итгэл хүлээхүйц байх зарчим (бүтцийн нэгжүүд тэдгээрийн удирдах албан тушаалын түвшин, нэр нь аль нэгж ямар асуудал эрхэлдэг, аль албан тушаал ямар эрх мэдэлтэй болохыг тодорхой мэдэж болохуйц байх, тэдгээрийн ажлын уялдаа, ажиллах чадвар нь итгэл хүлээхүйц байх);

3.1.3. Үзэгдэхүйц үйлчилгээний болон стратегийн удирдлагын баримжаатай байх зарчим (байгууллагын нэр, бүтцээс тухайн байгууллагын үйл ажиллагааны дүр төрх харагдахуйц байх, тухайлбал яамны бүтэц, бүтцийн нэгжийн нэр нь түүний үйл ажиллагааны стратегийг тусгасан байх);

3.1.4. Бүтцийн хувьд энгийн байх зарчим (тухайн яамны Төрийн нарийн бичгийн даргаас

хамгийн доод нэгжээ хүртэл гурваас дээшгүй шат дамжлагатай байх);

3.1.5. Тэнцвэрийг хангах, хяналтын хүрээг тогтоох зарчим (байгууллагын үйл ажиллагааны стратеги, бүтэц хоёрын зөв зохистой тэнцвэрийг хангах замаар аль болох хялбар удирдах, хянах боломжтой байх, үйл ажиллагааны стратегийн зорилтыг аль болох оновчтой бүлэглэх замаар бүтцийн ерөнхий тогтолцоог тогтоосон байх, энэ нь удирдлагын чиг үүрэг, хүн хүчний болон бусад нөөцийг зөв хуваарилан хэрэглэгчийнхээ хэрэгцээнд нийцсэн үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүлсэн байх);

3.1.6. Улс төрийн хувьд төвийг сахисан байх зарчим (тухайн яамны төрийн захиргааны албан хаагч нь тухайн сайд, Засгийн газар (танхим), бусад үйлчлүүлэгч буюу хэрэглэгчдэд улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүй, төвийг сахисан өндөр мэргэшлийн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх);

3.1.7. Хангалттай чадавхи, бодитой үйл ажиллагааны зарчим (үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар, зохион байгуулалтын бүтэц нь чадавхиа бүрэн илрүүлэхэд чиглэсэн хэрэгжихүйц бөгөөд ажиллах чадвартай байх).

3.2. Үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар

Дээрх зарчим болон Зам, тээвэр, аялал жуулчлалын яамны үйл ажиллагаа (Бизнес)-ны загварыг үндэслэн тус яамны үйл ажиллагааны бүтцийн дор дурдсан ерөнхий тогтолцооны загварыг санал болгож байна:

ЗАМ, ТЭЭВЭР, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮТЦИЙН ЕРӨНХИЙ ТОГТОЛЦООНЫ ЗАГВАР



3.3. Зохион байгуулалтын бүтэц

Зам, тээвэр, аялал жуулчлалын яамны үйл ажиллагаа (бизнес)-ны стратегийн болон үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загварыг үндэслэн тус яамны зохион байгуулалтын бүтцийн дор дурдсан нэгжийг санал болгож байна:

3.3.1. Стратегийн төлөвлөлт, бодлого зохицуулалтын асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Авто замын бодлого зохицуулалт, Тээврийн бодлого зохицуулалт, Аялал жуулчлалын бодлого зохицуулалт, Шуудангийн бодлого зохицуулалтын нэгжүүд нь үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд Зам, тээвэр, аялал жуулчлалын сайдын эрхлэх ажлын хүрээний салбаруудын бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл боловсруулах, бодлогын шинжилгээ хийх, бодлогын хувилбар гаргах, зөвлөгөө өгөх үндсэн үүргийг хүлээж салбарын урт, дунд, богино хугацааны стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах, бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл боловсруулах, бодлогын хэрэгжилтийг зохицуулах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжүүдийн үйл ажиллагаа нь Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд, Засгийн газрын танхимын үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэхэд чиглэнэ. Энэ нь Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд, Засгийн газрыг стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах, бодлогын зохицуулалттай холбогдсон шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх, Засгийн газрын гишүүн, Зам, тээвэр, аялал жуулчлалын сайдыг шаардлагатай мэдээлэл, өндөр мэргэшлийн, цаг үеэ олсон, шуурхай зөвлөгөө, бүх талын дэмжлэгээр хангах замаар хэрэгжинэ.

Эдгээр нэгжүүдээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд, Засгийн газрын танхим байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь бусад яам, Засгийн газрын тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлаг, нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж болон хэвлэл, мэдээлэл, олон нийтийн байгууллага, иргэд байна. Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Сангийн яам, Гадаад хэргийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар байна.

3.3.2. Төрийн захиргааны удирдлагын асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд төрийн захиргааны удирдлагын болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах үндсэн үүргийг хүлээж, яамны үйл ажиллагаанд удирдлагын шилдэг тэргүүний туршлага, арга зүйг нэвтрүүлэх, хүний нөөцийн

удирдлага, хөгжлийн асуудлыг шийдвэрлэх, ажлаа тайлагнах, хариуцлага тооцох тогтолцоог хөгжүүлэх, яамны аппаратын дотоод ажлыг зохицуулах зэрэг үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ. Энэ нэгжийн үйл ажиллагаа нь цомхон, чадварлаг төрийн албан хаагч бүхий төрийн захиргааны мэргэшсэн албаны хүчээр яамны тасралтгүй, хэвийн жигд ажиллагааг хангахад чиглэнэ.

Энэ нь Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд, дэд сайд, Төрийн нарийн бичгийн даргад болон яамны аппаратад шийдвэр боловсруулан гаргах, хэрэгжүүлэхэд эрх зүйн болон дотоод үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай мэдээлэл, зөвлөгөө, дэмжлэгээр хангах, удирдлагын соёл, чадавхийг дээшлүүлэх тэргүүний арга барил, туршлагыг нэвтрүүлэх, төрийн захиргааны албан хаагчдын сургалтыг зохион байгуулах, тэдний үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг нь хангах замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, төрийн захиргааны албан хаагчид байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь Засгийн газрын тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлаг, аж ахуйн нэгж, бусад хэрэглэгч байна. Энэ нэгжийн үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Хууль зүй, дотоод хэргийн яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, боловсрол сургалтын болон эрдэм шинжилгээний байгууллага байна.

3.3.3. Бодлогын хэрэгжилтэд хяналт шинжилгээ (мониторинг) хийж, үнэлж дүгнэх нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд бодлогын хэрэгжилтэд хяналт шинжилгээ (мониторинг) хийх, үнэлж өгөх үндсэн үүргийг хүлээж, эрхэлсэн салбарын бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийн явц, байдалд хяналт шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, хэрэглэгчдийг мэдээллээр хангах зэрэг үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх бөгөөд төрийн захиргаа, удирдлагын газрын бүтцэд хэлтсийн зохион байгуулалтаар ажиллана. Энэ нэгжийн үйл ажиллагаа нь яамны бодлого боловсруулах, түүний хэрэгжилтийг зохицуулах, төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, үйл ажиллагааны үр дүнд дээшлүүлэхэд чиглэнэ. Энэ нь бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төслийн хэрэгжилт, үр дагаврыг үнэлж замаар яамны бүтцийн нэгжүүдийн болон бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцож байгаа бүх байгууллага, тэдгээрийн удирдах, гүйцэтгэх албан тушаалтны үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн зөвлөгөө, дэмжлэгээр цаг тухайд нь хангах замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь сайд, дэд сайд. Төрийн нарийн бичгийн дарга, яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд. Засгийн газрын холбогдох агентлаг байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь бусад яам, хэрэглэгч байна. Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, сургалт, эрдэм шинжилгээний байгууллага байна.

3.3.4. Санхүү, хөрөнгө оруулалт, гадаад хамтын ажиллагааны нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 4 дүгээр зорилтын хүрээнд салбарын санхүү, хөрөнгө оруулалт, Зам, тээвэр, аялал жуулчлалын сайдын төсвийн багцын төлөвлөлт, санхүүжилт, зээл, тусламжийг зохицуулах, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд: Эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөвт авто, төмөр зам, агаар, усан замын тээвэр, аялал жуулчлал, шуудангийн салбарын зорилт арга хэмжээг нэгтгэн боловсруулж тусгуулах. Зам, тээвэр, аялал жуулчлал, шуудангийн үйлчилгээний салбарын эдийн засгийн үзүүлэлтүүдийн мэдээллийн санг бүрдүүлэн баяжуулж, салбарын статистик мэдээллийг нэгтгэн боловсруулж хэрэглэгчдийг мэдээллээр хангах. Зам, тээвэр, аялал жуулчлалын сайдын төсвийн төслийг нэгтгэн боловсруулах, батлагдсан төсөв, төлөвлөгөөг хуваарилах, гүйцэтгэл тайлагналтад

хяналт тавих, Авто замын болон аялал жуулчлалын санд улсын төсвөөс олгосон хөрөнгө оруулалтын санхүүжилтийг хуульд заасан эх үүсвэрүүдийн дагуу төвлөрүүлэх, зарцуулалт, гүйцэтгэлийг хянаж, бүртгэлд тусгах, гадаадын зээл, тусламж болон улсын төсвийн хөрөнгө оруулалттай төслийн санхүүжилт, гүйцэтгэлийг хянаж, бүртгэлд тусгах, салбарын худалдан авах ажиллагааг төлөвлөж зохион байгуулах, салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх ажлыг нэгтгэж зохицуулах зэргээр хэрэгжинэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь зам, тээвэр, аялал жуулчлал, шуудангийн салбарын эдийн засаг, хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх, салбарын стратегийн зорилтыг биелүүлэхэд боломж олгох бүх талын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд чиглэгдэх ба олон улсын гэрээ, хэлцлийн баримт бичиг боловсруулах, Засгийн газар хоорондын болон олон талын хэлэлцээрт оролцох асуудлыг зохицуулах, гадаад орон, олон улсын байгууллагад салбарын чиглэлээр санал тавьж, мэдээлэл өгөх зэрэг хэлбэрээр хэрэгжинэ.

Тухайн нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, бусад хэрэглэгчид байна. Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Сангийн яам, Гадаад хэргийн яам, гадаадын хандивлагчид, хөрөнгө оруулагчид байна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 3 дугаар сарын 7-ны өдөр

Дугаар 29

Улаанбаатар хот

Ажилд томилох тухай

Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, Эрүүл мэндийн сайд Л.Гүндалайн саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Алтанхуягийн Отгонболдыг Эрүүл мэндийн дэд сайдаар томилсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

Л.ГҮНДАЛАЙ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 3 дугаар сарын 7-ны өдөр

Дугаар 31

Улаанбаатар хот

Ажилд түр томилох тухай

Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 12 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

яамны Төрийн нарийн бичгийн даргаар түр томилсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

Л.ГҮНДАЛАЙ

Бямбаагийн Батсэрээдэнийг Эрүүл мэндийн

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 3 дугаар сарын 7-ны өдөр

Дугаар 32

Улаанбаатар хот

Төрийн өмчийн хорооны бүрэлдэхүүнд оорчлолт оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

2.Н.Батсуурь, Р.Бат-Эрдэнэ, Х.Пүрэвсүрэн, А.Мөнхбат нарыг Төрийн өмчийн хорооны гишүүнээс чөлөөлсүгэй.

1. Төрийн өмчийн хорооны гишүүнээр Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ч.Хүрэлбаатар, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Мишигжав, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга Ж.Сүхбаатар, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Батсэрээдэнэ нарыг тус тус томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**
М.ЭНХБОЛД
**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**
С.БАТБОЛД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 3 дугаар сарын 7-ны өдөр

Дугаар 33

Улаанбаатар хот

Тооны дээд хязгаар тогтоох тухай

Монгол Улсын Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

2. Цэргийн дүйцүүлэх албыг зохих журмын дагуу хаалгах ажлыг зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

1. 2006 онд цэргийн албыг дүйцүүлэн хаах иргэний тооны дээд хязгаарыг хавсралт ёсоор баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**
М.ЭНХБОЛД
**БАТЛАН ХАМГААЛАХЫН
САЙД**
М.СОНОМПИЛ

Засгийн газрын 2006 оны 33 дугаар тогтоолын хэвсрэлт

2006 ОНД ЦЭРГИЙН ДҮЙЦҮҮЛЭХ АЛБАНД ЭЛСҮҮЛЭХ ИРГЭДИЙН ТООНЫ ДЭЭД ХЯЗГААР

№	Аймаг, нийслэл	Тооны дээд хязгаар
1	Архангай	135
2	Баян-Өлгий	100
3	Баянхонгор	163
4	Булган	30
5	Говь-Алтай	54
6	Говьсүмбэр	10
7	Дархан-Уул	20
8	Дорноговь	46
9	Дорнод	20
10	Дундговь	40
11	Завхан	60
12	Орхон	15
13	Өвөрхангай	35
14	Өмнөговь	30
15	Төв	50
16	Увс	60
17	Сүхбаатар	70
18	Сэлэнгэ	30
19	Ховд	50
20	Хөвсгөл	62
21	Хэнтий	75
22	Улаанбаатар	85
Бүгд		1240



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 3 дугаар сарын 1-ний өдөр

Дугаар 34

Улаанбаатар хот

Мөнгөн төлбөрийн хэмжээг тогтоох тухай

Монгол Улсын Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 6 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. 2006 онд цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний төлөх төлбөрийн хэмжээг 888000 (найман зуун наян найман мянган) төгрөг байхаар тогтоосугай.

2. Мөнгөн төлбөрийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Батлан хамгаалахын сайд М.Сономпил, Сангийн сайд Н.Баяртсайхан нарт, мөнгөн төлбөрийг холбогдох хууль тогтоомжийн дагуу төлүүлэх арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД
БАТЛАН ХАМГААЛАХЫН
САЙД**

**М.ЭНХБОЛД
М.СОНОМПИЛ**

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

2006 оны 02 дугаар сарын 20-ны өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

АВТОТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ХЭСЭГ, ЗААЛТЫГ ТАЙЛБАРЛАХ ТУХАЙ

Автотээврийн тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг нэг мөр ойлгох, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5.-д заасныг удирдлага болгон Монгол Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

1. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5.-д заасан "тээвэрлэлтийн үйлчилгээ хэрэглэгч" гэдэгт Иргэний хуулийн 380 дугаар зүйлд заасан тээвэрлэлтийн гэрээний оролцогч болох зорчигч буюу ачаа, тээш тээвэрлүүлж буй этгээдийг хэлнэ.

2. Хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4.-т "нийтийн тээвэр, шуудан тээвэрлэлтийг тухайн нутаг дэвсгэрт зохицуулах, зохион байгуулах" гэдэгт Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1.-д заасны дагуу аймаг хооронд, орон нутаг, хотын доторхи болон хот орчмын нийтийн тээвэр, шуудан тээвэрлэлтийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг олгох эрхтэй аймаг, Нийслэлийн Засаг дарга нь харьяа албаараа дамжуулан нийтийн тээврийн үйлчилгээний замын чиглэл, шугам, цагийн хуваарь зэргийг батлах, тээвэрлэлтийн үйлчилгээний чанарыг сайжруулах талаар арга хэмжээ авах, тээвэрлэлтийн гэрээний үнэ тарифын дээд хязгаарыг тогтоох зэрэг ажиллагааг хамааруулан ойлговол зохино.

3. Хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.-д "Зорчигч, ачаа тээвэрлэлтийн үнэ хөлсний хэмжээг

оролцогч талуудын тохиролцож байгуулсан гэрээгээр тогтооно" гэсний "гэрээ" гэдгийг Иргэний хуулийн 380 дугаар зүйлд заасан тээвэрлэлтийн гэрээ гэж ойлгож, энэхүү гэрээний "оролцогч талууд" гэдэгт тухайн гэрээний оролцогч болох тээвэрлэгч болон тээвэрлүүлэгчийг ойлгоно.

4. Хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.-д "энэ хуулийн 15.2., 15.3., 15.4.-т заасан тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага нь тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллага, иргэнтэй гэрээ байгуулна" гэсний "гэрээ" нь Иргэний хуулийн 189 дүгээр зүйлийн 189.2., 189.3.-т заасан эрх олгох болон, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1.-д заасан нийтийн эрх зүйн гэрээ тул Иргэний хуулийн 380 дугаар зүйлд заасан тээвэрлэлтийн гэрээнд хамааралгүй гэж ойлгоно. Харин хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4.-т заагдсан эрх бүхий этгээд нийтийн тээвэр, шуудан тээвэрлэлтийг тухайн нутаг дэвсгэрт зохицуулж, зохион байгуулах арга хэмжээүүдийг энэхүү гэрээний гол нөхцөл болгон тусгасан байвал зохино.

**ЕРӨНХИЙ ШҮҮГЧ
ТАНХИМЫН ТЭРГҮҮН**

**С.БАТДЭЛГЭР
ЦАМАРСАЙХАН**

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

2006 оны 2 дугаар сарын 20-ны өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

Эмийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн зарим заалтыг тайлбарлах тухай

Эмийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн зарим заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5-д заасныг удирдлага болгон Монгол Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

1. Хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.1-д "байгууллагыг торгож, хууль бусаар олсон орлогыг нь хураах ба давтан үйлдвэл үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг хүчингүй болгох" гэснийг дараах байдлаар тайлбарласугай.

Хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.2-т заасан "эмийн үйлдвэрлэл, хадгалалт, тээвэрлэлтийн технологийн шаардлагыг хангаагүй нөхцөлд үйл ажиллагаа явуулсан байгууллага", мөн зүйлийн 7.5-д заасан "улсын стандартын шаардлагыг хангаагүй эм хангамжийн байгууллагыг" тус тус торгож, хууль бусаар олсон орлогыг хураана.

"Хууль бусаар олсон орлого" гэдэгт эмийн үйлдвэрлэл, хадгалалт, тээвэрлэлтийн технологийн шаардлагыг хангаагүй нөхцөлд үйл ажиллагаа явуулсны улмаас хүний болон мал, амьтны өвчнийг эмчлэх, оношлох, урьдчилан сэргийлэх зориулалтаар ашиглах боломжгүй болсон, чанарын баталгаа хангахгүй эмийн борлуулалт, үйлчилгээгээс олсон орлогыг хамааруулан ойлгоно.

Дээр дурьдсан эмийн үйлдвэрлэл, хадгалалт, тээвэрлэлтийн технологийн шаардлагыг хангаагүй нөхцөлд үйл ажиллагаа явуулсан зөрчлийг хоёр ба түүнээс дээш гаргасан бол "давтан үйлдэл" гэж үзэх бөгөөд энэ нь үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг хүчингүй болгох үндэслэл болно.

Энэ заалтын "торгох", "хууль бусаар олсон орлогыг хураах", "зөвшөөрлийг хүчингүй болгох" арга хэмжээг зэрэг хэрэглэж болно.

2. Хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.2-т "эм болон хууль бусаар олсон орлогыг хураах", "иргэн, албан тушаалтан, байгууллага, аж ахуйн нэгжийг торгох" гэдгийг дараах байдлаар ойлгож хэрэглэсүгэй.

Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д "Эмийн улсын бүртгэлд бүртгэгдсэн эмийг импортлохыг зөвшөөрнө", мөн зүйлийн 8.3-т "зохиж байгууллагын

зөвшөөрөлгүй эм импортлохыг хориглоно" гэж заасныг тус тус зөрчсөн бол иргэн, албан тушаалтан, байгууллага, аж ахуйн нэгжийн оруулж ирсэн эм, түүний борлуулалтаас олсон орлогыг хураахын зэрэгцээ тэдгээрийг тус бүр торгох арга хэмжээ авна.

3. Хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4 дэх заалтын "энэ хуулийн 9.2-ыг зөрчсөн бол хууль бусаар олсон орлогыг хурааж, зөрчил гаргасан иргэн, албан тушаалтан, байгууллага, аж ахуйн нэгжийг торгох" гэдгийг хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2-т заасан "эм нэвтрүүлэхээр тогтоосон хилийн боомтоос бусад боомтоор эм нэвтрүүлэхийг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн иргэн, албан тушаалтан, байгууллага, аж ахуйн нэгжид хамааруулахаас гадна хууль бусаар олсон орлогыг хураахын зэрэгцээ тэдгээрт торгох арга хэмжээ ногдуулан гэж ойлговол зохино.

Энэ заалтын "хууль бусаар олсон орлого" гэдэгт эм нэвтрүүлэхээр тогтоосон хилийн боомтоос бусад боомтоор нэвтрүүлсэн эм болон түүнийг борлуулсны орлогыг хамааруулан ойлгоно.

4. Хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.5-д энэ хуулийн 10.1, 10.2, 11 дүгээр зүйлийн заалтыг "зөрчсөн тохиолдолд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг хурааж улсын орлого болгох буюу устгах, худалдсан тохиолдолд хууль бусаар олсон орлогыг хурааж улсын орлого болгох" гэсэн заалтыг дараах байдлаар ойлгож хэрэглэсүгэй.

Хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д заасан малын эм ба хүний эмийн үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл аваагүй, мөн 10.2-т заасан эмийн үйлдвэрлэл эрхлэх үндсэн шаардлагыг хангаагүй эмийн үйлдвэрлэл эрхэлсэн, түүнчлэн хуулийн 11 дүгээр зүйлд заасан эмийн үйлдвэрлэл эрхлэхэд хориглох зүйлийг зөрчсөн байгууллагын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг хурааж, улсын орлого болгох буюу устгана. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ худалдан борлуулсан бол үнийг хууль бусаар олсон орлогод тооцон хурааж, улсын орлого болгоно.

5. Хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.5-д заасан "зөрчил гаргасан албан тушаалтан, байгууллагыг ...торгох буюу эм, эмнэлгийн хэрэгсэлийн үйлдвэрлэл эрхлэх зөвшөөрлийг 6 сараас 1 жил, 6 сарын хугацаагаар хүчингүй болгох" гэдгийг малын эм ба хүний эмийн үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл аваагүй, түүнчлэн эмийн үйлдвэрлэл эрхлэх талаар хуульд заасан үндсэн

шаардлагыг хангахгүйгээр эмийн үйлдвэрлэл эрхэлсэн, эмийн үйлдвэр эрхлэхэд хуулиар хориглосон зүйлийг зөрчсөн тохиолдолд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг хурааж, улсын орлого болгох, устгах, гэдэгт хуулиар олсон орлогыг хурааж улсын орлого болгохын зэрэгцээ, зөрчил гаргасан байгууллагыг торгох буюу эм, эмнэлгийн хэрэгслэлийн үйлдвэрлэл эрхлэх зөвшөөрлийг зургаан сараас нэг жил зургаан сарын хугацаагаар хүчингүй болгоно гэж ойлгоно.

Энэ заалтын "торгох" ба "эм, эмнэлгийн хэрэгслэлийн үйлдвэрлэл эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгох" арга хэмжээг зөрчлийн шинж байдлаас шалтгаалан аль нэгийг нь сонгон хэрэглэнэ.

6. Хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.8-д энэ хуулийн 7.7-г зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол эм болон хууль бусаар олсон

орлогыг хурааж, зөрчил гаргасан иргэн, албан тушаалтан, байгууллага, аж ахуйн нэгжийг торгох ба үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг 2 жил хүртэл хугацаагаар хүчингүй болгох" гэж заасныг дараахь байдлаар тайлбарласугай.

Хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д "хуурамч эм импортлох, үйлдвэрлэх худалдахыг хориглоно" гэж заасныг зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол "эм болон хууль бусаар олсон орлогыг хураах", зөрчил гаргасан иргэн, албан тушаалтан, байгууллагыг "торгох", "үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг хоёр жил хүртэл хугацаагаар хүчингүй болгох" арга хэмжээг нь зэрэг хэрэглэнэ гэж ойлгоно.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ
С.БАТДЭЛГЭР
ШҮҮГЧ
А.ДОРЖГОТОВ
МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

2006 оны 2 дугаар сарын 20-ны өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг тайлбарлах тухай

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг нэг мөр ойлгох, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5-д заасныг удирдлага болгон Монгол Улсын Дээд Шүүхээс ТОГТООХ нь:

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль (цаашид "хууль"-гэх)-ийн зарим зүйл, хэсэг, заалтыг дор дурьдсанаар тайлбарласугай.

1. Хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.6-д <<Хуулийн этгээдийн нэр өөр хуулийн этгээдийн нэртэй давхардсан>> гэдэгт Хуулийн этгээдийн өөрийн үйл ажиллагааг явуулахад ашиглах оноосон нэр нь бичвэр, хэлбэр авиан дуудлагын хувьд Улсын татварын Ерөнхий газрын дэргэдэх Улсын бүртгэлийн албаны Хуулийн этгээдийн нэрийн нэгдсэн жагсаалтанд бүртгэгдсэн бусад хуулийн этгээдийн нэртэй ижил байхыг ойлгоно.

2. Хуулийн 27 дугаар зүйлийн 27.4-т <<Хуулийн этгээдийн бүртгэлийн тухай хууль тогтоомжийг удаа дараа буюу ноцтой зөрчсөн>> гэсний <<удаа дараа>> гэдгийг энэ хуулийн 2 дугаар зүйлийн 2.1-д заасан хууль, тогтоомжийн актанд заасан шаардлагыг Хуулийн этгээд үл биелүүлэн гурав буюу түүнээс дээш зөрчснийг, <<ноцтой зөрчсөн>> гэдгийг Хуулийн этгээдийг үүсгэн байгуулах баримт бичиг, өөрийн хөрөнгө болон улсын бүртгэлийн жагсаалтыг хуурамчаар

бүрдүүлсэн, эсхүл үүсгэн байгуулах баримт бичигт заасан үйл ажиллагааны зорилгоос гажсан, мөн бусдад төлөх өр төлбөрөөс зайлсхийж, хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах зохирол төр, иргэд, хуулийн этгээдэд их хэмжээний хөхирол учруулсан буюу үчруулж болох зөрчлийг ойлгоно.

3. Хуулийн 28 дугаар зүйлийн 28.3-т зааснаар хууль хүчин төгөлдөр болсноос хойш арван найман сарын буюу 2005 оны 4 дүгээр сарын 1-ний дотор Хуулийн этгээд нь хуульд заасан баримт бичгийг бүртгэх байгууллагад ирүүлээгүй бол тухайн хуулийн этгээдийг татан буулгах эсэх асуудлыг бүртгэх эрх бүхий байгууллагын саналыг үндэслэн анхан шатны шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 133 дугаар зүйлийн 133.1.1, 135 дугаар зүйлийн 135.2.14-т зааснаар хэрэг хянан шийдвэрлэх онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэнэ.

Шүүхийн шийдвэрт Иргэний хуулийн 32 дугаар зүйлд заасан журмын дагуу ажиллагаа хийхийг бүртгэх байгууллагуудад даалгасан байвал зохино.

Хуулиар тусгайлан харьяалуулсан тул Улс төрийн намыг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгахтай холбоотой асуудлыг Улсын Дээд шүүх анхан шатны журмаар хянан шийдвэрлэнэ.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ
С.БАТДЭЛГЭР
ШҮҮГЧ
Д.ТУНГАЛАГ

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

2006 оны 2 дугаар сарын 20-ны өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

Шүүхийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсгийн зарим заалтыг тайлбарлах тухай

Шүүхийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсгийн "хуульч мэргэжлээрээ ажилласан хугацаа" гэсэн заалтыг нэг мөр ойлгох, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5-д заасныг удирдлага болгон Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

1. Шүүхийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсгийн "хуульч мэргэжлээрээ ажилласан хугацаа" гэдэгт эрх зүйч мэргэжлээр хууль зүйн дунд болон дээд боловсрол эзэмшсэн хүн зайлшгүй ажиллавал зохих дараах ажил, албан тушаалд ажилласан хугацааг тооцно. Үүнд:

а. Бүх шатны шүүхийн шүүгч, прокурор, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, шийдвэр гүйцэтгэгч, өмгөөлөгч, нотариатч, арбитрч, тэдгээрийн туслах ажилтан, нарийн бичгийн дарга;

б. Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, бүх шатны шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Үндсэн хуулийн цэц, Прокурорын байгууллага, Төрийн албаны зөвлөл, Хүний эрхийн үндэсний комисс зэрэг төрийн бусад байгууллагуудын тамгын газар, хэрэг эрхлэх газар, ажлын албаны болон тэдгээрийн харьяа хэлтэс, тасгийн ажилтнууд;

в. Цагдаа, гааль, татвар, тагнуул, хорих, хилийн цэрэг зэрэг байгууллагын ажилтнууд;

г. Төрийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллага, хууль зүйн товчоо, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагуудын ажилтнууд /архивч, кодификаторч, бичиг хэргийн эрхлэгч, эрх зүйн мэдээллийн ажилтан гэх мэт/;

д. Хууль зүйн их, дээд сургууль, коллеж, түүнтэй адилтгах сургалтын байгууллагын багш,

хууль зүйн эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагын ажилтнууд;

2. Энэ тогтоолын 1 дэх хэсэгт зааснаас бусад ажил, албан тушаалд ажилласан тодорхой тохиолдол, хуульч мэргэжлээр ажилласан хугацаатай холбогдон гарсан маргааныг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 133 дугаар зүйлийн 133.1.1-д заасан онцгой ажиллагааны журмаар шүүх хянан шийдвэрлэнэ.

3. Хуульч мэргэжлээр ажилласан хугацааг тоолоходоо шүүгчийн албан тушаалд нэр дэвшигчийн нийгмийн даатгалын дэвтэр, түүнтэй адилтгах баримт бичгийг үндэслэх бөгөөд хуульч мэргэжлээр ажилласан хугацааг тасарсан эсэхийг харгалзахгүйгээр энэ тогтоолын 1 ба 2 дахь хэсэгт заасан ажил, албан тушаалд ажилласан бүх хугацааг нэгтгэн бүтэн 12 сарыг нэг жилд, шүүгчийн албан тушаалд нэр дэвшигчийн насыг тооцоходоо иргэний үнэмлэх, түүнтэй адилтгах баримт бичгийг үндэслэн төрснөөс хойши бүтэн 12 сарыг нэг насанд тус тус тооцно.

4. Хөдөлмөрийн тухай хуулийн 35 дугаар зүйлд заасан үндэслэлээр ажил, үүргээ гүйцэтгээгүй үед ажил, албан тушаалыг хэвээр хадгалах тохиолдлыг хуульч мэргэжлээр ажилласан хугацаанд оруулна.

5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Улсын Дээд шүүхийн 1993 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 40 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

С.БАТДЭЛГЭР

ТАНХИМЫН ТЭРГҮҮН

О.ЗАНДРАА

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар-12
Төрийн ордон

☎ 265958
Индекс 14003

☎ 329487
Хэлсэлийн хуудас 2.5

